



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖ, УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ,
ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

2022 он

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖ, УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ,
ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

2022.06.09

Д/д	Шийдвэрийн утга, огноо, дугаар	Хариуцах албан тушаалтан	Заалт	Хэрэгжилт	Хувь	Хуурч Тасарсан болон удааширч байгаа шалтгаан
1	Татварын багц хуулийн хэрэгжилт	Татварын байцаагч	<p>-2-р бүлэг 10-р зүйл хөнгөлөлт, чөлөөт</p> <p>- 6-р бүлэг 25-р зүйл татвар төлөгчийн бүртгэл</p> <p>6-р бүлэг 28-р зүйл татвар ногдуулалт, төлөлт</p> <p>6-р зүйл 29-р зүйл татварын тайлан хүлээн авах</p> <p>9-р бүлэг 41-р зүйл татварын хяналт шалгалт</p> <p>11-р бүлэг 4-р зүйл татварын буцаан олгох,суутган тооцох</p> <p>11-р бүлэг 51, 52-р зүйл татварын нэхэмжлэх, өр төлүүлэх дараалал</p>	<p>ААНОАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлтөд 8, аж ахуйн нэгж, орон сууц болон оюутны сургалтын төлбөрийн хөнгөлөлт чөлөөлөлтөд 46 иргэн хамрагдсан.</p> <p>Шинээр 3 ААН-г бүртгэж төрлийн бүртгэлд бүртгэсэн. 2022 оны 06 сарын 10-ны байдлаар өссөн дүнгээр татварын орлогын төлөвлөгөөний биелэлт:</p> <ul style="list-style-type: none"> - Улсын төсөвт 94,532.0 мянган төгрөг оруулахаас 171,228.3 мянган төгрөг буюу 181.1 хувь - Аймгийн төсөвт 83,899.8 мянган төгрөг оруулахаас 127,775.6 мянган төгрөг буюу 152.3 хувь - Сумын төсөвт 421,589.0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 281,385.9 мянган төгрөг буюу 66.7 хувь <p>Нийт 600,020.8 мянган төгрөг төвлөрүүлэхээс 580,389.9 мянган төгрөг буюу 96.7 хувиар биелүүллээ. Тайлангийн ирц:2021 оны 4-р улирал, 2022 оны 1,2-р улирал 100%, мөн нэмэгдсэн өртгийн албан татварын тайланг сар бүр 15-15 буюу 100%, Татварын өр төлүүлэх нэхэмжлэх 13 ААН-д хүргүүлж 1 ААН-н данс битүүмжилж нийт 13 ААН-д шат дараалсан арга хэмжээ авсан.</p>	100%	

2	Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай	Хүнс ЖДҮ, хоршоо хариуцсан мэргэжилтэн	Хуулийг хэрэгжүүлэх	Сумын Засаг даргын баталсан удирдамжийн дагуу 2 удаа хяналт шалгалт хийж давхардсан тоогоор 22 аж ахуйн нэгж хамрагдсан. Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтанд ЕБС, 1 болон 2-р цэцэрлэг, суманд худалдаа үйлчилгээ эрхэлдэг цайны газрууд, цех, мини маркет, хүнсний дэлгүүр, бар, караоке зэрэг газрууд хамрагдсан.	100%	
3	Статистикийн тухай хууль	Төрийн сангийн мэргэжилтэн, статистикч	2-р бүлэг 4, 5, 6 - р зүйл 5-р бүлэг 20, 21-р зүйл	Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэн төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, иргэдийн төлөөлөгчдийн хуралд тайлагнаж, төсвийг сар, улирлын хуваарилалтандаа багтаан зарцуулж, өр авлага үүсгэхгүй хэмнэлтийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллаж байна	100%	
4	Төсвийн тухай хууль	Санхүү албаны дарга	Хуулийг хэрэгжүүлэх	Статистикийн тухай хуулийг өдөр бүр хэрэгжүүлэн холбогдох мэдээ тайлан, тооллого судалгаануудыг цаг хугацаанд нь гаргаж, мэдээ мэдээллийг тухай бүр шинэчлэн программд шивж, файлаар болон цаасаар аймгийн статистикийн хэлтэст хүргүүлэн, хэрэглэгчдийг мэдээллээр ханган ажиллаж байна.	100%	
5	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай	Засаг даргын орлогч, Санхүү албаны дарга	Хуулийг хэрэгжүүлэх	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг хэрэгжүүлэн, төсөвт байгууллагуудын эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, захиран зарцуулалтад хөндлөнгийн хяналт тавьж эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулан үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн тайланг ТБОНӨЭХ бүргэлийн /Тө-1, Тө-2, Тө-3, Тө-15/ маягтуудыг төсөвт байгууллага бүрээр гарган аймгийн ОНӨГазарт хүргүүлэн ажиллаж байна.	100%	
6	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль	Хөдөлмөр эрхлэлт, халамж хариуцсан мэргэжилтэн	Хуулийг хэрэгжүүлэх	Хөдөлмөр эрхлэлтийн тухай хууль болон Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2022 оны 02 сарын 14-ны өдрийн тогтоолын хэрэгжилтийг талаар төсөл хөтөлбөрт хамрагсан	70%	

				иргэдэд, олон нийтэд мэдээллэх ажлын Цагааннуур Хөдөлмөр халамж, Цагааннуур ЗДТГ-ын пэйж хуудсуудаар дамжуулан суртачилан таниулж байна.		
7	Байгаль орчныг хамгаалах тухай хууль	БОХУБ, байгаль хамгаалагч	Хуулийг хэрэгжүүлэх	Сумын цагдаагийн албатай хамтран хууль бус мод бэлтгэлээс урьдчилан сэргийлж Ноён уул, Тосонгийн амны чиглэлд хөдөлгөөнт эргүүл, хяналт шалгалт хийсэн. Мөн сумын иргэдийн түлээний мод бэлтгэл, модны эрхийн бичигт байгаль хамгаалагчид хяналт тавин ажилласан. 2021 оны намрын судалгаагаар Бургасны бүгэгт Тамгын хоолойгоос Шүрэн хүртэл 1000 га талбайд хийж гүйцэтгэж саналыг аймгийн БОАЖГазарт хүргүүлсэн. Байгаль хамгаалагчид малын гоц халдварт Шүлхий өвчний хяналтын постонд 5 удаа 3 хоногоор постонд ажилласан. Постонд ажиллах хугацаанд байгаль орчны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг давхар хийж гүйцэтгэсэн.	70%	
8	Нийгмийн даатгалын тухай хууль	Нийгмийн даатгалын байцаагч	Хуулийг хэрэгжүүлэх	Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан нийгмийн даатгалын мэдээллийн санд бүртгэлтэй ажил олгогчдод зориулсан сургалт зохион байгуулж, мэдээлэлтэй тулган шалгаж хамрагдаагүй аж ахуйн нэгжүүдийг нийгмийн даатгалд хамруулж шинээр 1 ажил олгогч, 4 албан журмын даатгуулагч хамруулсан байна. Сайн дурын даатгалд 13 малчин даатгуулахаас 16 малчин даатгуулагч, ажил хөдөлмөр эрхлээгүй иргэн, хувиараа хөдөлмөр эрхлэгч 5 иргэн даатгуулахаас 26 иргэн иргэнийг хамруулсан байна. Эхний хагас жилийн байдлаар шинээр тэтгэвэр тогтоолгох 38 иргэний материал хүлээн авснаас 35 иргэний тэтгэвэр тогтоогдож тэтгэврээ авч байна. Үүнээс өндөр насны тэтгэвэр-20, тахир дутуугийн тэтгэвэр-13, тэжээгчээ алдсаны тэтгэвэр-2 иргэн	100%	

				тогтоолгосон байна. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагчдын тэтгэврийг сар бүрийг сар бүрийн 1-ний дотор олгож, тэтгэмжийг хууль журмын дагуу хугацаанд олгож иргэдэд чирэгдэлгүй үйлчилсэн байна. Оршуулгын тэтгэмжийн материал 6 иргэн, ажилгүйдлийн тэтгэмж 16 иргэн, жирэмсэн амаржсан болон хөдөлмөрийн чадвар алдалтын тэтгэмжийн 90 иргэнд олгосон байна.		
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ						
1	2010.01.14 №63	И.Наранбаатар	Мод тарих үндэсний өдөр зарлах тухай	Шинэбадрах ХХК нь, Бүтээлийн нуур ХХК нь Хүрмэн ой ХХК-иар ойжуулалтын ажлыг гүйцэтгүүлсэн. Бүтээлийн нуур ХХК Сангалтайд 20 га талбайд шинэс модны суулгацаар, Шинэ бадрах ХХК Гүн шүрэнд 20 га талбайд шинэс модны суулгацаар хийсэн. Ойжуулалтын ажлыг байгаль хамгаалагч Ц. Мөнхтөр, сум дундын ойн ангитай хамтран гүйцэтгэлийг шалгалаа. Сумын хэмжээнд Иргэд гоёлын мод-21 ширхэг, жимсний мод-32 ширхгийг, ААНБайгууллага гоёлын мод-82 ширхэг, жимсний мод-68 ширхгийг тарьсан байна. Нийт шилмүүст мод-188 ширхэг, гоёлын мод-103 ширхэг, жимсний мод-100 ширхгийг тарьсан байна.	100%	
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ						
1	2022.03.16 № 121	Д.Амарсанаа	2022 онд өмчлүүлэх газрын нийт хэмжээ байршил зориулалтыг тогтоох тухай	Газар өмчлүүлэхээр нийт 15 өргөдөл хүлээн авч 4 иргэнд газар өмчлүүлсэн байна. мөн цахимаар 60 хүсэлт хүлээн авч 56 хүсэлтийг шийдвэрлэж, 4 хүсэлт шийдвэрлэх шатандаа явж байна.	100%	
2	2022.02.23 № 81	Ч.Хонгорзул	Хоршооны хөгжлийг дэмжих талаар авах зарим арга хэмжээний тухай	2022 оныг хоршооны хөгжлийг дэмжих жил-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтэнд хяналт тавих ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.	50%	
3	2022.02.16 № 74	Ц.Батдэлгэр	ХАА-н ээлжит тооллого явуулах тухай	Сумын Засаг даргын А/69 тоот захирамжаар ажлын хэсэн томилогдон удирдлага зохион	100%	

				байгуулалтаар ханган тооллогыг 06-р сарын 02-наас 06-р сарын 15-ны хооронд зохион байгуулж байна. Тооллогод хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 402 /давхардсан тоогоор/ өрх, аж ахуйн нэгж бүрэн хамрагдаж тооллогыг амжилттай зохион байгуулан хяналтын тооллогыг 06 сарын 06 наас 19-ны хооронд зохион байгуулан ажиллаж байна.		
АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН ТОГТООЛ						
1	2022.01.20 № 02	Д.Алтанзориг	Коронавируст халдварын тархалтын түвшинг тогтоож үйл ажиллагааны горимд шилжүүлэх тухай	Аймгийн Онцгой комиссын тогтоолын дагуу халдварын тархалтыг 7 хоног бүр хийж эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийг тухай бүр бүрдүүлсэн. Халдварын нөхцөл байдлаас шалтгаалан Цагаан сарын баярыг гэр бүлийн хүрээнд тэмдэглэх, нийтийг хамарсан золголт зохион байгуулахгүй байх талаар сурталчилгааг хийж ажилласан.	100%	
2	2022.04.01 № 05	Д.Алтанзориг	Хорио цээрийн онцгой дэглэм тогтоох тухай	Сумын Онцгой комисс 2022 оны 03 дугаар сарын 20-ны өдөр хуралдаж өвчний сэжиг илэрсэн бүс нутагт “Түр хязгаарлалтын дэглэм” тогтоож хяналтын 3 цэгт хөл хорио тогтоон цагдаа, ЗДТГ-ын мэргэжилтнүүдийн бүрэлдэхүүнтэй пост гарган орох, гарах хүн, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг бүрэн хаасан. Өвчний шинж тэмдэг илэрсэн өрхийн хашаа хороо, өвөлгөө, өтөг бууцын 8165 мкв талбайг уурын мананцаржуулагчаар халдваргүйтгэж малчидад зөвлөмж зөвлөгөө өгч дээд шатны байгууллагыг мэдээ мэдээллээр ханган ажилласан. Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораторын 2022 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 22/1168 тоот шинжилгээний дүнгээр мал, амьтны гоц халдварт шүлхий өвчин болох нь тогтоогдсон тул сумын Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 23-ын өдрийн А/36 тоот	100%	

				<p>захирамжаар 28 хоногийн хугацаатай “Хорио цээрийн дэглэм” тогтоон Улсын онцгой комиссын 2022 оны 03 дугаар сарын 23-ний өрийн 02 дугаар тогтоолын дагуу ажилласан.</p> <p>Мал эмнэлгийн ерөнхий газраас хувиарын дагуу ирсэн вакциныг сумын Засаг даргын А/40 тоот захирамжаар эрүүл, хамгаалалтын бүсэд дархлаажуулалтын 11 баг гарган шуурхай зохион байгуулан ажиллаж байна.</p> <p>Яаралтай дархлаажуулалтанд нийт 25290 толгой үхэр, 1350 гахай, 42316 толгой бог тус тус хамруулсан.</p>		
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН АЛБАН ДААЛГАВАР						
1	2022.04.01 № 01	И.Наранбаатар	Төв суурин газрын тохижилтыг сайжруулах хог хаягдлыг зайлуулах, ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг эрчимжүүлэх тухай	2022 оны 05-р сарын 22 нд сургууль, 1, 2-р цэцэрлэг, эрүүл мэндийн төв, ахмадын хороо, соёлын төв зэрэг байгууллагуудад хогийн цэгийн урд хэсэг болон хог хаягдал ихтэй газруудыг хувиарлан өгч цэвэрлүүлсэн. Нийт 125 хүн, 2 портер машин цэвэрлэгээнд хамрагдсан бөгөөд 4 тн хог хаягдал түүж цэвэрлэн хогийн цэгт буулгасан.	70%	
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ						
1	2022.02.11 А/52	Д.Алтанзориг	Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийн бэлтгэл ажил хангах тухай	Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийн бэлтгэл ажлын хүрээнд сумын Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж ерөнхий зориулалтын мэргэжлийн ангиудын бэлтгэл бэлэн байдлыг шалгасан.	100%	
2	2022.03.03 А/79	Б.Отгонцэцэг	Хурдан морины уралдаанч хүүхдийн амь нас эрүүл мэндийг хамгаалах тухай	1.Засгийн газрын 2019 оны “Хурдан морины уралдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 57 дугаар тогтоолоор “Жил бүрийн 11 дүгээр сарын 1-ний өдрөөс 5 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл хугацаанд хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээ зохион байгуулахыг хориглосон”, мөн Сэлэнгэ аймгийн засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн А/79 тоот захирамжыг сумын ЗДТГ-ын цахим хуудас болон	50%	

				<p>Цагааннуур сумын 3 цахим хуудаст 5 удаагийн давтамжтай сурталчилж ажиллалаа.</p> <p>2.Хориглосон хугацаанд буюу 2022 оны 03 дугаар сарын 19-ний өдөр сумын Тийрэг 3 дугаар баг хөдөө гэх газар хурдан морины бооцоот уралдаан зохион байгуулагдах гэж байна гэсэн мэдээллийн дагуу сумын хамтарсан баг, хүүхэд хамгааллын багийн 8 хүний бүрэлдэхүүнтэй баг 2 хэсэг болон хуваагдаж тухайн газар очиж шаардлага тавьж тараах арга хэмжээг авч ажиллалаа.</p> <p>2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс хойш тус суманд 2 удаа хурдан морины уралдаан зохион байгуулагдсан бөгөөд унаач хүүхдийн хамгаалах хэрэгсэл бүрэн бүтэн эсэх, хүүхдийн эрсдлийн болон амь насны даатгал хийлгэсэн эсэхэд хамтарсан багийн гишүүд хяналт тавин ажиллаж байна.</p>		
3	2022.03.29 A/97	И.Наранбаатар	Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээний тухай	<p>Хаварын хуурайшилтын үеийн бэлэн байдлыг ханган ажиллах ажлын хүрээнд байгаль хамгаалагч нар түймрийн үлээгч болон бусад хэрэглэгдэх багажнуудыг засаж, сэлбэх ажлыг хийж гүйцэтгэж бэлэн байдлыг хангаж ажилласан.</p> <p>Сумын хэмжээнд байгаль хамгаалагч нар тус тусын хариуцсан бүс нутгийн 211 малчин өрхийн 427 иргэнд, 8 ААНБайгууллагад ойн тухай хууль, хог хаягдлын тухай хууль, түлээний мод бэлтгэхэд анхаарах зүйлс, ойн дагалт баялаг, жимс жимсгэний тухай, ан амьтны тухай хууль багтаасан САНАМЖ тарааж гарын үсгийн баталгаа авч ажилласан.</p>	70%	
4	2022.03.30 A/110	М.Алтаннавч	Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, шилжилт хөдөлгөөнийг хориглох хяналт тавих	<p>Тус суманд 2022 онд мал, амьтны гоц халдварт А01 шүлхий болон үхэрт галзуу өвчин УМЭАЦТЛ-ын шинжилгээгээр оншлогдсон.Улсын онцгой комиссын тогтоолын дагуу А01 шүлхий өвчинтэй цэмцэх арга хэмжээг шуурхай зохион байгуулан ажиллаж өвчлөл гарсан өдрөөс хойш 20 хоногийн</p>	100%	

			ажлыг шуурхай зохион байгуулах тухай	<p>хугацаанд ил шинж тэмдэг илрээгүй тул хорио цээрийн дэглэмийг цуцлаж 14 хонгийн хугацаатай хязгаарлалтын дэглэм тогтоон 3 чиглэлт байсан постыг буулгаж малын эмч нар идэвхтэй болон идэвхгүй тандалт хийн тухай бүр мал эмнэлгийн тасагт мэдээлэн ажиллаж байна.</p> <p>2022 оны 04-р сарын 19-ний өдөр эрүүл горимд шилжин халдварын дараах ариутгал халдваргүйтгэл хийж нийт 94500м2 талбайг Нисорын уусмалаар ариутгав.</p> <p>Мал, амьтны шилжилт хөдлөгөөнд хяналт тавьж амьдаар гадагшаа 41 адуу, 247 толгой үхэр, 1208 толгой хонь, 313 толгой ямаа, 29 толгой гахай' тус тус амьдаар үржилд болон үйлдвэрлэл худалдаа, хүнсэнд гадагшаа гарсан ба МЭҮН-д мэдэрхүйн аргаар гадна үзлэг хийж мал эмнэлгийн гэрчилгээ үүсгэж мал эмнэлгийн улсын байцаагч хяналт тавьж баталгаажуулсан байна.</p> <p>Мал амьтны шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж Сүхбаатар аймгийн Халзан сумаас тус сумын Оргих 1 дүгээр багт 15 тооны адуу оруулж ирэх замд нь саатуулж буцаах арга хэмжээ авч ажиллав.</p>		
5	2022.03.30 A/111	М.Алтаннавч	Гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх сэг зэм устгал, ариутгал, отор нүүдэл, шилжилт хөдөлгөөнийг зохицуулах арга хэмжээ авах тухай	<p>Сумын Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн А/58 тоот захирамжаар сэг зэм, ариутгал халдваргүйтгэлийн сарын аян зарлаж сумын хэмжээнд зохион байгуулан ажилласан.</p> <p>Гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ариутгал халдваргүйтгэлийн ажлыг сумын хэмжээнд 4 МЭҮН-ийн эмч нар Түүхий эд, бүтээгдэхүүн хадгалах цэг, зоорь, тэжээлийн агуулах-6ш-4720м2, Малын хашаа, хороо, мал амьтны тоног хэрэгсэл-187ш-98505м2, Худаг уст цэг-5ш-260м2, Голомтын бүсийн талбай-19695м2, Устгалын цэгийн талбай-5000м2, нийт 123180с2 талбайд Нисор-50кг,</p>	100%	

				<p>Superkill-10кг, Рикоцит-5кг тус тус зарцуулж халваргүйтгэл хийсэн байна.</p> <p>Мал, амьтны шилжилт хөдөлгөөнд байнга хяналт тавьж ажилласан. Сумын хэмжээнд одоогийн байдлаар</p> <p>Мал амьтны өвчлөл, отор нүүдэл шилжилт хөдөлгөөнд байнгын хяналт тавьж ажиллав.</p> <p>Гоц халдварт, халдварт өвчний идэвхтэй, идэвхгүй үзлэг тандалтыг 2022 оны 01 дүгээр сараас 5 дугаар сар дуустал сумын хэмжээнд 500 өрхийн малчин, мал бүхий өрх, ААН-ийн адуу-2000, үхэр-25000, хонь-60000, ямаа-50000, гахай-1300 толгой мал амьтанд хийж гүйцэтгэн заавар зөвлөгөө өгч ажиллав.</p> <p>Байгаль хамгаалагч багийн дарга нартай хамтран 1.2.3. дугаар багийн нутаг дэвсэрт ил задгай хясан үхэр-15, хонь-56, ямаа-33 гахай-4, нохой-2, муурны 1 сэг зэм болон малын арьс ширийг малчидын оролцоотой булж устган ариутгаж, уг ажлын зорилго, ач холбогдлын талаар нийт 250 малчин, мал бүхий өрх, ААН-д мэдээлэл өгч мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллав.</p>		
6	2022.04.05 A/126	Д.Алтанзориг	Хугацаат цэргийн албаны ээлжит татлага зохион байгуулах тухай	2022 оны нэгдүгээр ээлжийн хугацаат цэргийн албаны татлагын эрүүл мэндийн үзлэгт цэргийн насны 51 залуучуудыг хамруулж 1 иргэн эрүүл мэндийн үзлэгээр тэнцсэн. Эрүүл мэндийн шалтгаанаар 6 иргэн цэргийн албанаас чөлөөлөгдсөн.	100%	
7	2022.04.21 A/155	Д.Алтанзориг	Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулах тухай	Сумын засаг даргын А/63 тоот захирамжаар 17 хүний бүрэлдэхүүнтэй төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг тооллогын ажлыг зохион байгуулах ажлын хэсэг байгуулагдаж, төсөвт байгууллагуудын тооллогын явцад хяналт тавьж аргазүйн зөвлөгөөгөөр ханган төрийн болон орон нутгийн өмчит байгууллагууд байгууллагын эзэмшил ашиглалтад байгаа эд хөрөнгийг	100%	

				тооллогод 05 сарын 02-наас 06 сарын 10-ны хооронд бүрэн хамруулж дууссан. Байгууллагуудын үзлэг тооллогын баримтыг аймгийн ажлын хэсэгт хүлээлгэж өгөх бэлтгэл ажил хангагдсан.		
8	2022.01.07 А/09	Д.Алтанзориг	2022 оны тээврийн улсын үзлэг явуулах тухай	2022 оны 05-р сарын 25-27 ний өдрүүдэд авто тээврийн улсын үзлэг болж нийт 687 тээврийн хэрэгсэл, үүнээс суудлын автомашин 355, ачааны автомашин 294, зүтгүүр 1, автобус 4, цэстэрн 2, тусгай зориулалтын 2, механизм 8, чиргүүл 4, мотоцикл 17 тус тус хамрагдлаа.	100%	
9	2022.05.06 А/189	Д.Алтанзориг	Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль зохион байгуулах тухай	Аймгийн хэмжээнд Гамшгаас хамгаалах иж бүрэн дадлага, сургууль 06 сарын 3-5-ны өдрүүдэд “Танхимын сургалт”, “Бэлэн байдлын үзлэг”, “Штабын дадлага”, “Дадлага, сургууль” гэсэн үндсэн дөрвөн хэсэгтэйгээр явагдлаа. Штабын дадлага сургууль нь сумын нутаг дэвсгэрт хүчтэй газар хөдлөлт, малын гоц халдварт өвчин болсон үеийн удирдлагын хариу арга хэмжээ, шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх, мэргэжлийн анги, албадын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор гамшгаас хамгаалах хүч хэрэгсэл, бэлэн байдлын төлөвлөгөөг тодотгох, өгөгдсөн цагийн байдлын дагуу бүлгээр ажиллах дадлагаар явагдлаа. “Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль”-ийн иргэдийг аюулгүй нүүн шилжих дадлага сурууль 2022 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн өглөө 10:00 цагт түр цугларах талбайд, сургуулилтад 589 иргэн хамрагдлаа.	100%	
10	2022.05.04 А/177	Б.Отгонцэцэг	Үндэсний бичигтэн 2022-2024 хөдөлгөөн өрнүүлэх тухай	Аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн А/177 тоот захирамжаар батлагдсан “Үндэсний бичигтэн 2022-2024” хөдөлгөөний удирдамжийн дагуу сумын ЗДТГ-ын 22 албан хаагчаас үндэсний бичгийн төвшин тогтоох сорилыг авч ажиллалаа. Сорилын үр дүнд үндэсний бичиг огт мэдэхгүй-4 албан хаагч, дунд	30%	

				шатны мэдлэгтэй-14 албан хаагч, ахисан шатны мэдлэгтэй-4 албан хаагч байна. Судалгааны үндсэн дээр анхан, дунд, ахисан шатны сургалтуудыг төлөвлөн ажиллаж байна.		
11	2022.05.11 А/193	Д.Алтанзориг	Төр, захиргааны байгууллагуудын ажлын цагийн хуваарьт түр өөрчлөлт оруулах тухай	Аймгийн Засаг даргын захирамжийн дагуу 05 дугаар сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл сумын төр, захиргааны байгууллагуудын ажлын цагийг 08.00-17.00 болгосон.	100%	
12	2022.05.10 А/191	И.Наранбаатар	Бүх нийтээр хог цэвэрлэх арга хэмжээг зохион байгуулах тухай	Хогийн нэгдсэн цэгт иргэд хогоо асгах зам талбай гаргах, түрж овоолго хийх, булшлах зэрэг ажлыг Бүтээлийн нуур ХХК-тай 1 жилийн хугацаатай гэрээ хийж гүйцэтгэлд нь хяналт тавин ажиллаж байна. 2022 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн Сумын Засаг даргын А/37 тоот “Бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгуулах тухай” захирамжын дагуу 2022 оны 03 дугаар сарын 24-нөөс 26-ны өдрүүдэд зохион байгуулан ЗДТГ-ын 4 ажилтан албан хаагчид, Хүнсний талонд хамрагддаг 14 иргэд, Худалдаа үйлчилгээ эрхэлдэг иргэд, 9 аж ахуй нэгж байгууллагуудаас 120 иргэн, нийтдээ 160 иргэн хог цэвэрлэгээнд оролцож ойр орчмынхоо 50м болон сумын төв доторх 1,3 км засмал замыг цэвэрлэж нийт 4 тн хогийг хогийн нэгдсэн цэгт буулгалаа.	70%	
13	2022.05.11 А/195	И.Наранбаатар	Тэрбум мод-Их ажлын эхлэл хөдөлгөөнийг орон нутагт зохион байгуулах тухай	1. “Тэрбум мод-Цагааннуур сум 2022” зөвлөгөөнийг 5 сард зохион байгуулж, зөвлөгөөнөөр сум дундын ойн ангиас мод тарилтын тухай мөн Шаамар сумын мод үржүүлгийн 2 нэгж мод үржүүлгийн талаар тус тус илтгэл тавьж иргэдэд мэдээлэл хүргэж, модны тарьц худалдаалсан. Зөвлөгөөнөөр сумын 2-р цэцэрлэгийн хамт олон зөвлөгөөнд хүрэлцэн ирсэн 50 гаруй иргэнд цэцэгний үр бэлэглэж идэвхи санаачлагатай оролцож ажилласан.	100%	

				Тэр бум мод ажлын хүрээнд мод бэлтгэлийн мэргэжлийн байгууллага болох Бүтээлийн нуур ХХК, Шинэбадрах ХХК-иудаар фермийн урд талаар зам дагуулан 12*50 метрийн хэмжээтэй 4 хашаа бариулж үүнд сумын сургууль, 1,2-р цэцэрлэг, эрүүл мэндийн төв зэрэг байгууллагууд 150 ширхэг нарс мод тарьсан.		
14	2022.05.11 A/194	И.Наранбаатар	Бүх нийтээр мод тарих арга хэмжээг зохион байгуулах тухай	1. Шинэбадрах ХХК нь, Бүтээлийн нуур ХХК нь Хүрмэн ой ХХК-иар ойжуулалтын ажлыг гүйцэтгүүлсэн. - Бүтээлийн нуур ХХК Сангалтайд 20 га талбайд шинэс модны суулгацаар, - Шинэ бадрах ХХК Гүн шүрэнд 20 га талбайд шинэс модны суулгацаар хийсэн. Ойжуулалтын ажлыг байгаль хамгаалагч Ц. Мөнхтөр, сум дундын ойн ангитай хамтран гүйцэтгэлийг шалгалаа. 2. Сумын хэмжээнд Иргэд гоёлын мод-21 ширхэг, жимсний мод-32 ширхгийг, ААНБайгууллага гоёлын мод-82 ширхэг, жимсний мод-68 ширхгийг тарьсан байна. Нийт шилмүүст мод-188 ширхэг, гоёлын мод-103 ширхэг, жимсний мод-100 ширхгийг тарьсан байна.	70%	
15	2022.05.17 A/210	Ц.Батдэлгэр	ХАА-н ээлжит тооллого зохион байгуулах тухай	Сумын Засаг даргын А/69 тоот захирамжаар ажлын хэсэн томилогдон удирдлага зохион байгуулалтаар ханган тооллогыг 06-р сарын 02-наас 06-р сарын 15-ны хооронд зохион байгуулж байна. Тооллогод хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 402 /давхардсан тоогоор/ өрх, аж ахуйн нэгж бүрэн хамрагдаж тооллогыг амжилттай зохион байгуулан хяналтын тооллогыг 06 сарын 06 наас 19-ны хооронд зохион байгуулан ажиллаж байна	100%	
16	2022.05.11 A/197	М.Алтаннавч	Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх	Сумын Засаг даргын 2022 оны 05 сарын 26-ны өдрийн А/75 “Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах тухай”	100%	

			<p>нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах тухай</p>	<p>зархирамж гаргаж хэрэгжилтийг хангаж ажилласан.</p> <p>Гоц халдварт, халдварт өвчний идэвхтэй, идэвхгүй үзлэг тандалтыг 2022 оны 01 дүгээр сараас 5 дугаар сар дуустал сумын хэмжээнд 500 өрхийн малчин, мал бүхий өрх, ААН-ийн адуу-2000, үхэр-25000, хонь-60000, ямаа-50000, гахай-1300 толгой мал амьтанд хийж гүйцэтгэн заавар зөвлөгөө өгч ажиллав.</p> <p>Мал, амьтны гоц халдварт А01 шүлхий болон үхэрт галзуу өвчин УМЭАЦТЛ-ын шинжилгээгээр оншлогдсон.Улсын онцгой комиссын тогтоолын дагуу А01 шүлхий өвчинтэй цэмцэх арга хэмжээг шуурхай зохион байгуулан ажиллаж өвчлөл гарсан өдрөөс хойш 20 хоногийн хугацаанд ил шинж тэмдэг илрээгүй тул хорио цээрийн дэглэмийг цуцлаж 14 хонгийн хугацаатай хязгаарлалтын дэглэм тогтоон 3 чиглэлт байсан постыг буулгаж малын эмч нар идэвхтэй болон идэвхгүй тандалт хийн тухай бүр мал эмнэлгийн тасагт мэдээлэн ажиллаж байна.</p> <p>2022 оны 04-р сарын 19-ний өдөр эрүүл горимд шилжин халдварын дараах ариутгал халдваргүйтгэл хийж нийт 94500м2 талбайг Нисор-ын уусмалаар ариутгав.</p> <p>А01 шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх 2 дахь тун вакцинжуулалтыг 2022.03.24-өөс 4 дүгээр сарын 07-ны өдөр хүртэл шуурхай зохион байгуулж нийт 25290 толгой үхэр, 1350 гахай, 42316 толгой бог тус тус хамруулсан.</p> <p>Үхрийн арьс товруутах өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг 05 сарны 12-ны өдрөөс 10 хоногийн хугацаанд зохион байгуулж сумын хэмжээнд 24400 толгой үхэр хамруулсан.</p>		
--	--	--	--	--	--	--

				<p>Шөвөг яр өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтанд нийт 48200 толгой хурга ишиг хамруулсан.</p> <p>Боом өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад нийт 13800 толгой бод, 22800 бог хамруулахаас 10000-бод, 18000-бог хамруулаад байна.</p> <p>Дуут хавдар нийт 8800 толгой үхэр хамруулах төлөвлөөтэй үнээс 4800 толгой үхэр хамруулаад гүйцэтгэл 60% байна.</p> <p>Галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилганд 3800-бод, 600-нохой хамруулахаас 3800 толгой үхэр, 600 нохой тус тус хамруулж гүйцэтгэл 100% мал эмнэлгийн цахим системд оруулаад байна.</p> <p>Шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх 2022 оны нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж сумын Ирэгдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулж аймгийн мал эмнэлгийн газарт хүргүүлсэн. Угаалга-136100, туулгалт-116846, боловсруулалт-95280 толгой мал, амьтан, Гуурын боловсруулалтанд-14500 толгой үхэр, нохой, муурны үржил таслах арга хэмжээнд 20, нийт 362746 толгой мал, амьтан шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулахаар төлөвлөн ажиллаж байна.</p> <p>Үүнд Боловсруулалтанд-65730 толгой мал, амьтан гүйцэтгэл 63%, , Туулгалтанд-59020 толгой мал, амьтан гүйцэтгэл-52%, Угаалганд-5650 буюу гүйцэтгэл 9% тай эхний хагас жилд хийгдсэн байна.</p>		
17	2022.05.29 A/230	Д.Алтанзориг	Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт түр шилжүүлэх тухай	Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуульд сумын Онцгой комисс, гамшгаас хамгаалах шуурхай штаб, мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүн өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжин ажилласан.	100%	
СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ						

1	2022.01.28 № 42	М.Гоомарал	Сумын ойн сангаас 2022 онд түлээний мод бэлтгэх хуваарь батлах тухай	Багийн байгаль хамгаалагчид мод бэлтгэлийн 2 аж ахуй нэгжид мод бэлтгэх талбай тусгаарлалтын ажлыг сум дундын ойн ангитай хамтран хийж гүйцэтгэж, мод бэлтгэлтгэлийн үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна.	70%	
2	2022.04.05 № 51	Ч.Хонгорзул	Хяналт тавих орон тооны бус зөвлөл байгуулах тухай	2022 оны 04 сарын 05 өдөр дугаар 51 ИТХ тогтоол. Хоршоо хөгжүүлэх сангийн хяналт тавих орон тооны бус зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсан. Дарга Я.Идэрнамнан ИТХ төлөөлөгч Нарийн бичгийн дарга Ч.Хонгорзул ЖДҮХСХС мэргэжилтэн М.Оюун-Эрдэнэ Эмэгтэйчүүдийн зөвлөлийн дарга Ц.Отгонжаргал Худалдаа үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн холбооны тэргүүн нар сонгогдон ажиллахаар болов. Хоршоо хөгжүүлэх сангийн орон тооны бус хяналтын зөвлөл хуралдан хугацаа хэтэрсэн зээлдэгчдийн эрэн төлөлтийг сайжруулах. Төслийн чиглэлээр зээл авсан иргэдийг чиглэлийн дагуу үйл ажиллагаа эрхлэж байгаа эсэхийг шалгаж байна.	50%	
3	2022.04.05 50	Ч.Хонгорзул	Хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулах чиглэл тогтоох тухай	2022 оны 04 сарын 05 өдөр дугаар 50 Хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгийн ажлын байр бий болгох, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, амьжиргааг сайжруулах, орон нутгийн тогтвортой хөгжлийг хангах зорилгоор 5 чиглэл 1. Арьс шир, ноос ноолуур боловсруулах 2. Мал үржлийн технологийн ажил үйлчилгээний нэгжийг дэмжих 3. Мал нядалгааны цех байгуулахад дэмжлэг үзүүлэх 4. Нарийн боовны цехийн өргөтгөлд дэмжлэг үзүүлэх 5. Авто угаалга, засварын газар шинээр барих болон өргөтгөхөд дэмжлэг үзүүлэх чиглэлүүдээр ИТХ-аар батлуулсан. Төслийг чиглэлийн дагуу төсөлөө хүлээн авах тал дээр анхааран ажиллаж байна	50%	
4	2022.04.25 № 58	М.Алтаннавч	2022 оны мал амьтан шимэгчтэх өвчнөөс	Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалтанд тусгагдсан	100%	

			сэргийлэх төлөвлөгөө батлах тухай	<p>мал, амьтны шимэгчтэх өвчний төлөвлөгөөг жил бүр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлуулах ажлыг төлөвлөн 2022 оны 04 сарын 25-ны өдрийн 58 дугаар тогтоолоор батлуулж хэрэгжилтийг технилогит хугацаанд зохион байгуулж төлөвлөгөөг 100% мал эмнэлгийн цахим системд оруулж гүйцэтгэлт хяналт тавин ажиллав. Угаалга-136100, туулгалт-116846, боловсрулалт-95280 толгой мал, амьтан, Гуурын боловсруулалтанд-14500 толгой үхэр, нохой, муурны үржил таслах арга хэмжээнд 20, нийт 362746 толгой мал, амьтан шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулахаар төлөвлөн ажиллаж байна. Үүнд Боловсруулалтанд-65730 толгой мал, амьтан гүйцэтгэл 63%, , Туулгалтанд-59020 толгой мал, амьтан гүйцэтгэл-52%, Угаалганд-5650 буюу гүйцэтгэл 9% тай эхний хагас жилд хийгдсэн байна</p>		
5	2022.05.20 № 62	Ч.Хонгорзул	Хоршоо хөгжүүлэх сангийн төсөл хүлээн авах, шалгаруулах тухай	<p>2022 оны 05 сарын 20 өдөр 62 тогтоол ИТХ-аар Хоршоо хөгжүүлэх сангийн төсөл хүлээн авах хугацааг 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрөөс 06 дугаар сарын 26-ны өдөр хүртэл, төслийн сонгон шалгаруулалтыг төсөл хүлээн авах хугацаа дууссанаас 20 хоногийн дотор явуулж дуусгахыг тогтоов.Төсөл хүлээн авах хугацаандаа явж байна.</p>	50%	